



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Г “Монгол секюритиес ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн Г
ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 61 дугаар зүйлийн 61.1.3 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1 дахь заалтууд, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дүгээр тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих” журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит бус хурлыг 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 10.00 цагт Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг 15 хороо, Гэгээнтэн цогцолбор 215 тоотод хуралдуулахаар тогтоосугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар доор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат гишүүнийг дэвшүүлэх, томилох
 - Дүрмийн санг нэмэгдүүлэх, зохистой харьцааны үзүүлэлтийг хангах ажиллах талаарх танилцуулга, төлөвлөгөө
 - Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
 - Бизнес төлөвлөгөө
 - Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 02 –ний өдрийн 186-р тогтоолоор батлагдсан “Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлийн нөхцөл, шаардлага, үйл ажиллагаанд хяналт тавих журам”-д заасны дагуу уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/ -ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 8 дугаар сарын 29-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тухай зарыг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр, 2023 оны 08 дугаар сарын 29-ны өдөр дахин мэдээлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерийн компанид хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.
5. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг хурал зохион байгуулах комиссын дарга /Л.Гүндэгмаа/-д гаргаж өгөхийг компанийн санхүүд даалгасугай.
6. Ээлжит бус хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хавсралт 1-д заасан бичиг баримтыг БДК-иудаас авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.
7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах “саналын хуудас”-ны агуулгыг хавсралт 2-т зааснаар баталсугай.
8. Компанийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2023 оны 9 дүгээр сарын 19-ны өдрийн 14 цагаар тасалбар болгосугай.
9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хурал зохион байгуулах бөгөөд тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:
 - М.Нэргүй дарга
 - Ц.Арилдийпүрэв гишүүн
10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс-д даалгасугай.
11. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “Монгол Секюритиес ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Хавсралт 3-д заасан маягтын дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо , Хөрөнгийн Бирж-д хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /Л.Гүндэгмаа/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/З.НОМУНДАРЬ /